



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

Зээлийн гэрээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр тогтоол, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн турбингенератор №4-ын шинэчлэлийн төслийг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт болох 21,000,000.00 (хорин нэгэн) сая хүртэл еврогийн зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулах эрх олгохыг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001700